

ГАЗАР бол уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах нэг хэрэгсэл мөн

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг бууруулахад чиглэгдсэн, 1990-ээд онуудын дунд үеэр хэлэлцэж баталсан Киотогийн протоколийг 2012 онд Киотогийн дараах үеийн гэрээгээр солих шаардлагатай болж байна. Одоогоор хэлэлцээний шатандаа байгаа уур амьсгалын өөрчлөлтийн талаарх гэрээ хэлэлцээр нь тухайн үедээ шинжлэх ухааны тодорхой бус байдлын улмаас Киотогийн протоколд хамруулаагүй буюу түүнээс хассан, дасан зохицох асуудал, нөлөөллийг бууруулах талаарх бодлогын хоосон үлдээсэн орон зайг нөхөх ёстой болж байна. Газар бол нүүрстөрөгчийг өөртөө агуулах өндөр чадавхитай бөгөөд энэ чанарыг тооцож, газрын өөртэй агуулсан олон олон боломжийг чухалчилж анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Газар нь органик нүүрстөрөгчийг ургамал, агаар мандлаас хоёр дахин илүү хэмжээтэйгээр хадгалж чадна.

Энэхүү товчооны хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа өнөөгийн гэрээний зарим заалтын учир дутагдалтай талуудыг, тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зорилгоор газар ашиглалтыг зохицуулах нэн ялангуяа доройтолд орсон газар нутаг, хуурай гандуу нутгийг онцгойлон авч үзэж, тэдгээрийг хэрхэн засаж залруулах талаар авч үзэх болно. Ингэснээр доройтолд орсон хөрсөн дахь нүүрстөрөгчийг сэргээх, газар тариалан эрхлэх, Рио-гийн конвенцүүдийн үйл ажиллагааг илүү ихээр уялдуулах зэрэг арга ажиллагааг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах боломж хэмээн хүлээн зөвшөөрүүлэх санал гаргана. Эцэстээ хуурай гандуу газар нутагт хөрсний өөрийнх нь нүүрстөрөгчийг шингээх үйл явцыг дэмжихүйц хөрөнгө оруулалт, түүнчлэн одоо хэлэлцээрийн шатандаа байгаа Киото-гийн дараах үеийн гэрээ хэлэлцээрт оруулахаар төлөвлөн байгаа газар тариалангийн үйлдвэрлэл дахь санхүүгийн механизмын оролцоог хамруулах явдлыг мөн санал болгож байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах өнөөгийн стратеги

Киото-гийн дараах үеийн гэрээ хэлэлцээрийг боловсруулахаар ажиллаж байгаа хүмүүс нь Киотогийн протоколын хүрээнд бий болсон суурь тогтолцоонд тулгуурлан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах стратегийг боловсруулж байна. Нэг улс орны тухайд бол татвар зэрэг зах зээлийн хэрэгслийн тусламжтайгаар хувь хүмүүсийн хэрэглээний хэв загварыг өөрчлөх зорилго тавьдаг бол, дэлхийн түвшин дахь санал санаачлага нь хоорондоо нарийн уялдаатай тогтсон системийн өөрчлөлтийг өдөөх хандлагатай байдаг. Өнөөдөр хэрэглэгдэж байгаа үндсэн хоёр стратеги нь хүлэмжийн хийн ялгарах явцыг багасгах (ХХ), илүүдэл ялгаралтыг бүрэн зогсоох явдал юм. Эдгээр стратегийг хэрэгжүүлэх дэлхийн хэмжээний бодлогын хэрэгслүүд бол Хорт хийн худалдаа (Emissions Trading), Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ, Clean Development Mechanism, CDM), Хамтын хэрэгжүүлэлт (Joint Implementation, JI), Хөгжиж буй орнуудад ойн хомсдлоос үүдэн бий болох хорт хийн ялгарах явдлыг багасгах (Reducing Emissions from Deforestation in Developing Countries, REDD) болно. Эдгээр хэрэгсэл нь хүлэмжийн хийг хэт ялгаруулагч хэн нэгэн, өөрсдийн тухайн үйлдвэрлэлийн явцдаа ялгаруулж байгаа хорт хийгээ хэдийгээр багасгахгүй боловч тодорхой түвшин хүртэлх хорт хийг ялгаруулж болох зөвшөөрөгдсөн хэмжээндээ хүрээгүй байгаа улс орноос ялгаруулж байгаа хорт хийг худалдаж авах, эсвэл гуравдагч орны хорт хийг ялгаруулах явдлыг багасгах боломжийг олгодог бөгөөд ингэснээр нийт дүнгээрээ дэлхийн түвшинд хорт хийн ялгаралт багасгах болно. Цэвэр хөгжлийн механизмийн арга хэрэгслийг ашиглаж хүлэмжийн хийг багасгаж байгаа явдлыг зөвхөн хүлэмжийн хийн

ялгаруулалтыг багасгах үүрэг хүлээгээгүй улс орнуудын хувьд хүлэмжийн хийгээ бууруулаа гэсэн байдлаар тэдний тооцооноос хасаж тооцдог. Харин хамтын хэрэгжүүлэлт гэдэг нь зөвхөн хорт хийн ялгаруулалтыг бууруулах үүрэгтэй улс хоорондын харилцан солилцооны тухай асуудал юм. Хөгжиж буй орнуудад ойн хомсдлоос үүдэн бий болох хорт хийн ялгарах явдлыг багасгах нь ялангуяа халуун бүсийн улс орнуудад ой модны хомсдолыг багасгах урамшууллын нэг болж өгдөг. Ийм бүсүүдэд хүлэмжийн хийн ялгаруулагчид нь ойг нөхөн сэргээх хөтөлбөрөөс кредит худалдан авах боломжтой. НҮБ-ийн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцийн 4-р зүйлд заасан хүлэмжийн хийг бууруулах стратеги нь биомасс, ой мод, далай, мөн хуурай газар, далай тэнгисийн эрэг орчим, далайн экосистем зэргийн хүлэмжийн хийг шингээх чадвар, мөн хадгаламжийн хэрэглээг хүлээн зөвшөөрдөг. Киотогийн протокол (2 ба 3 дугаар зүйл) нь эдгээр аргуудыг хүлээн зөвшөөрдөг байхад мөн протоколын 3.3 нь ойжуулалт, ой нөхөн сэргээлт, ойн хомсдолтой холбоотой бүх шингээлтийн цэвэр өөрчлөлтөөр л багасгалтыг хязгаарладаг. Энэхүү аргыг 2007 оны Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи Засгийн газар хоорондын ажлын хэсэг (IPCC)-ийн 3 дугаар ажиллах багийн тайлан дэмжсэн байдаг бөгөөд үүгээр 1990-ээд оны 5.8 гигатонн хэмжээтэй нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг ой модны хомсдолтой холбож, ой модны хомсдол нь богино хугацааны туршид хамгийн их нөлөөтэй, бас хамгийн сүүлийн



үеийн нүүрстөрөгчийн нөөцийн нөлөөллийг олгодог хэмээн дурьджээ. Эдгээр бодлогын урамшууллыг бүхэлд нь авч үзвэл бусад арга тухайлбал, нүүрстөрөгчийг шингээх бусад аргуудыг хэт багаар хэрэглэж байна.

Жишээлбэл, Хөдөө аж ахуйн салбар бүх хүлэмжийн хийн 10-12%-ыг үүсгэж, зарим хөдөө аж ахуй эрхлэгчид аль

хэдийнээ ялгаруулалтыг багасгах үйлд оролцож байгаа хэдий ч, хөгжиж буй орнуудад ойн хомсдлоос үүдэн бий болох хорт хийн ялгарах явдлыг багасгах (REDD) хэрэгслийн хүрээн дахь газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн аж ахуй (LULUCF)-н санал санаачлага нь хөдөө аж ахуйн тухайд хүлэмжийн хийг багасгах үйл ажиллагаанд бага анхаарч байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг багасгах стратеги

Киотогийн протоколд хөрс, ус, далай тэнгисийн үйл явцад түшиглэсэн нүүрстөрөгчийг шингээх санал санаачлага байгаагүй нь тухайн цаг үеийн шинжлэх ухаан энэ асуудалд тодорхойгүй байр суурьтай байсныг харуулж байгаа юм. Харин эдүгээ хөрсний нүүрстөрөгчийг шингээх асуудлаар шинжлэх ухаан өөрийн байр сууриа бүрэн олж чадсан байна. Хөрсний органик нүүрстөрөгчийг шингээх боломжийн талаархи нээлт, хөрсний нүүрстөрөгчийг шингээх байдлыг хэмжих талаар гарсан шинжлэх ухааны дэвшил, нүүрстөрөгчийн ялгаралтыг багасгах үйл ажиллагаанд олон тоогоор аль хэдийнээ оролцож эхэлсэн нутгийн ард иргэд, нүүрстөрөгчийг шингээх боломжтой ихээхэн хэмжээний газрын гадарга зэрэг нь энэ асуудалд, мөн энэ асуудлаарх зах зээлийн боломжийг нээх сонирхлыг ихээр бий болгожээ.

Нүүрстөрөгчийг шингээх хөрсний боломж

Хөрсөн дахь нүүрстөрөгч нь газар доорх биомасс, үхсэн органик бодис, мөн хөрсөнд өөрт нь агуулагдана. Газрын доройтол гэсэн ойлголтод ихэнхдээ биомассын алдагдал, хөрсний элэгдлийн улмаас бий болсон хөрсөн дахь нүүрстөрөгчийн алдагдал зэрэг орно. 1990 онд дэлхийн нийт газрын гадаргуугийн 15 орчим % нь доройтолд орсон байсан бол 2005 он гэхэд дахиад 25%-д нь доройтох үйл явц ажиглагдаж эхлэжээ. Дэлхийн хуурай газрын 40%-ийг эзлэх хуурай гандуу газар нутгийн 10-20% нь доройтсон хэмээх судалгааны дүн байдаг. Жил бүр хуурай гандуу нутгууд нь нийт ялгаруулалтын 4% буюу 0.23-0.29 гигатонн нүүрстөрөгчийг агаарт ялгаруулж байдаг. Хуурай гандуу газар нутаг уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн эмзэг байдаг явдал нь энэ байдлыг улам даамжруулах төлөв ажиглагдаж байна.

	Бүс нутаг бүрт байх хөрсөн дахь нүүрстөрөгчийн нийт агууламж (гт)	Хуурай, гандуу газар нутгийн нүүрстөрөгчийн агууламж (гт)	Бүс тус бүрт байх нүүрстөрөгчийн агууламжид хуурай гандуу газар нутаг дахь агууламжийн эзлэх хувь (%)
Хойд Америк	388	121	31
Гренланд	5	0	0
Төв Америк ба Кариб	16	1	7
Өмнөд Америк	341	115	34
Европ	100	18	18
Хойд Еврази	404	96	24
Африк	356	211	59
Ойрхи Дорнод	44	41	94
Өмнөд Ази	54	26	49
Зүүн Ази	124	41	33
Зүүн өмнөд Ази	132	3	2
Австрали/Шинэ Зеланд	85	68	80
Номхон далай	3	0	0
	2053	743	36

Хүснэгт1: Хуурай гандуу газар нутагт байх хөрсөн дахь нүүрстөрөгчийн агууламж

(Trumper, K., Ravilious, C. & Dickson, B. Carbon in Drylands: Desertification, Climate Change and Carbon Finance. A UNEP-UNDP-UNCCD Technical Note for Discussions at CRIC 7, Istanbul, Turkey - 2008 оны 11 сарын 03-14. 2008. UNEP-ийн нэрийн өмнөөс UNEP-WCM бэлтгэв)

Нөгөө талаас хуурай гандуу газар нутаг нь дэлхийн газрын экосистемийн нийт нүүрстөрөгчийн агууламжийн 36%-г өөртөө агуулдаг (Зураг 1-ийг харна уу). Нэгж талбайд оногдох ургамлын биомасс нь газрын бусад системд гектар бүрд 100-180 тонн байхад хуурай гандуу газар нутаг гектар бүрд 60 тонн буюу бага хэмжээтэй байгаа ч нийт эзлэх талбайн хэмжээ их, хөрсний доройтол өндөр тул хөрсний нүүрстөрөгчийн шингээлт явуулах боломж их юм. Өнгөрсөн үйл явцын улмаас нүүрстөрөгчийн хэмжээ буурсан экосистем нь нүүрстөрөгчийн хуримтлалынхаа хувьд түүнтэй харьцуулахуйц боловч нүүрстөрөгчийн агууламж ихтэй газраас хамаагүй илүү хэмжээний нүүрстөрөгчийг хуримтлуулсан байх боломжтой хэмээн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи Засгийн газар хоорондын ажлын хэсэг (IPCC) -ийн Гуравдугаар үнэлгээний тайланд бичжээ.

Доройтож элэгдсэн хуурай гандуу газар нутгийн хөрсийг сэргээхийн тулд хөрсөн дахь нүүрстөрөгчийн хэмжээг ихэсгэх ёстой бөгөөд үүнд, жилд 0.4-0.6 гигатонн нүүрстөрөгчийг шингээх хэрэгтэй ажээ. Органик болон органик бус хөрсийг засварлах бодисыг түүнийг хамгаалах дэвсгэр маягаар буюу хөрстэй нийлүүлэх замаар хөрсийг сэргээдэг. Хуурай гандуу газар нутгийн хөрсийг сэргээх энэхүү аргыг уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны хүрээнд хөрсний нүүрстөрөгчийн шингээлт гэнэ.

Хөрсний нүүрстөрөгчийн шингээлт нь хөрсийг сэргээхээс өөр ч ашиг тустай. Хуурай хөрс нь эрдэсжилтэд тэсвэртэй тул нойтон хөрсийг бодвол нүүрстөрөгчийг илүү удаан хугацаагаар хадгална (3-р хуудасны Зураг 2-ыг харна уу). Түүнээс гадна, ой мод бүхий газар нутагт ашиглаж байгаа арга ямагт богино хугацааных байх бөгөөд харин хөрсний нүүрстөрөгчийн шингээх явц нь дунд хугацааных байж, үүгээрээ бие биенээ нөхөх үйлчилгээтэй болдог. Ургамлын нас бие гүйцэж ойн шингээх чанар алдагдсаны дараагаар хөрсний нүүрстөрөгч нэмэгддэг хэмээх шинжлэх ухааны судалгаа байдаг. Хөрсний нүүрстөрөгчийг ихэсгэснээр хөрсний үржил шим, түүн дээр ажиллах боломж, усыг агуулах чадвар зэргийг ихэсгэн хөрсний элэгдлийг багасгадгийг бодолцвол хуурай гандуу газар нутагт хөрсөн дахь нүүрстөрөгчийн агууламжийг нэмэгдүүлэх явдал нь нь уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн нэрвэгдэж байгаа эмзэг хүн ардын тухайд уур амьсгалын өөрчлөлтийг багасгах ашигтай арга болох юм.

Ерөнхийдөө уур амьсгалын өөрчлөлтийг багасгах санал санаачлагыг хэмжих, түүнийг мэдээлэх, баталгаажуулах аргууд нь дэлхийн хэмжээний бодлогын санал санаачлагын тухайд хөрсөн дахь нүүрстөрөгчийн агууламжийг нэмэгдүүлэх тэрхүү үйл явцыг албан ёсоор уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх хамгийн том шаардлага болж байна. Гэлээ ч хөрсний нүүрстөрөгчийг хэмжихэд хялбар бөгөөд шинж чанарыг нь бодоход уур амьсгалын өөрчлөлтийн талаархи хамгийн тохиромжтой үзүүлэлт юм. Хөрсөн дахь нүүрстөрөгч нь сайтар тодорхойлогдсон шинж чанар бүхий, шууд болон өөр өөр хэмжээсийн дагуу (өргөн, урт, гүн, хугацаа) хэмжиж болдог, нэг газарт олон удаа дараалан хэмжих боломжтой, хүн бүрийн мэддэг зүйл. Хөрсөн дахь нүүрстөрөгч нь мөн өнгөрсөн цаг хугацааны мэдээллийг агуулж байдаг бөгөөд хөрсийг үүсэх үйл явцад чухал түлхэц болдог утгаараа экосистемийн үйл ажиллагаа, үйлчилгээ, мөн хөрсний үржил шимд чухал үүрэг үзүүлнэ.

Газар тариалан ба газрын тогтвортой менежмент

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи Засгийн газар хоорондын ажлын хэсэг (IPCC)-ийн Үнэлгээний дөрөвдүгээр тайлангаар нийт хүлэмжийн хийн 30%-г газар ашиглалтаас үүдсэн хүлэмжийн хийн ялгаруулалт эзлэж, үүний 10-12%-г эрчим хүч, бордоо, газрыг тариалангийн талбай болгон хувиргахтай холбоотой ялгарсан газар тариалангийн үйл ажиллагаанаас эхтэй гэжээ. Газар тариалангийн ба бэлчээрийн талбайн менежмент, доройтолд орсон хөрс ба газар тариаланд ашиглаж байгаа органик хөрсийг нөхөн сэргээх явдал нь нүүрстөрөгчийг багасгах хамгийн их боломжийг олгохоос гадна, мал гэрийн тэжээвэр амьтан, цагаан будааны талбайн менежмент нь азотын ислийг багасгах ихээхэн боломжийг бий болгоно хэмээн тус тайланд дурьджээ. Түүнээс гадна, тэрхүү ялгарч байгаа хүлэмжийн хийн бараг 90%-ийг хөрсний нүүрстөрөгчийн шингээлтээр багасгаж болно хэмээн дурьджээ. Хэдийгээр олон улсын хэмжээний бодлогын зүгээс эдгээр асуудлуудад анхаарал хандуулаагүй ч, зарим улс оронд хөдөө аж ахуй эрхлэгчид нүүрстөрөгчийн кредитийн үйл ажиллагаануудыг хөгжүүлж эхэлжээ. Нүүрстөрөгчийн ялгаруулалт, түүнийг шингээх боломж, хөдөө аж ахуйн бусад арга хэрэгсэлийн талаарх болон хөрсөн дахь нүүрстөрөгчийг хэмжих талаархи мэдлэг, мэдээлэл зэргийг авч үзвэл хөдөө аж ахуй эрхлэгчдийг шаардлагатай үйл ажиллагаанд өдөөх бодлогын урамшуулал хэрэгтэй байна.



Зураг1: Хөрсний нүүрстөрөгчийг шингээх боломж (янз бүрийн хөрсөн дахь)

(Lal, Rattan, 2009, p20, Carbon Sequestration in Relation to Climate, in Soil Amendments and Carbon Sequestration. ХБНГУ-ын Бонн хотноо 2009 оны 6 дугаар сарын 6-ны өдөр НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн газраас зохион байгуулсан Газар сэдэвт өдөрлөгийн цээр тавьсан илтгэл)

Газрыг эрчимтэйгээр хагалсны улмаас үүссэн элэгдэл, ойн хомсдол, бэлчээрийн талхагдал, модлог ургамал түрж ургах зэрэг нь хөрсний органик бодисийн хэмжээг бууруулж, цаашлаад хөрсний нүүрстөрөгчийн хэмжээг багасгана. Силвопасторализм (ойн аж ахуй, бэлчээрийн мал аж ахуйг нэгтгэсэн аж ахуйн төрөл), хөрсний хаалт/халхавч хэрэглэх явдал, азотыг сэргээдэг үр тарианы хэрэглээ, газар тариаланг сэлгээх арга замаар хөгжүүлэх зэрэг хөдөө аж ахуйн өөр сонголтууд нь хөрсний нүүрстөрөгчийг шингээх чадавхийг дээшлүүлдэг. Тэжээл үйлдвэрлэх замаар хаягдлыг багасгах, хөрсний элэгдлийг зогсоох, тариа хураасны дараа үлдэх үлдэгдлийг талбайд хэвээр нь үлдээх, газар хагалахгүйгээр тариалангийн аж ахуй эрхлэх зэрэг газрын тогтвортой менежмент, хамгаалах арга хэрэгслийг ашигласнаар хөрсний элэгдлээс сэргийлж улмаар хөрсний нүүрстөрөгчийн ялгаралтыг багасгах боломжтой.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц хоорондын харилцан уялдаа холбоо (синержи)

Уялдаа холбоо (синержи) гэдэг энэ ойлголт нь хоёр буюу түүнээс дээш тооны байгууллага хамтран ажиллах, ингэснээр

нийт үр ашиг нь тус тусдаа ажилласнаас бий болох үр ашиг тус бүрийн нийлбэр ашгаас илүү байх явдал юм. Рио-гийн гурван конвенцийн Хамтын уялдаа холбооны Бүлгэмийг байгуулсан явдал нь дээрх нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголтыг баталж өгсөн явдал болсон юм. Уур амьсгалын өөрчлөлт буюу Цөлжилт, газрын доройтол ба ган (ЦГДГ)-ийн харилцан хоёр талт нөлөөллийг авч үзвэл тодорхой нэг улсын түвшинд харилцан уялдаа холбоог дээшлүүлэх хэрэгцээ шаардлага, мөн боломж ч байгаа юм. Эдгээр конвенц нь мөн ижил төстэй гурван зорилтыг өмнөө тавьсан байна.

Нэгдүгээрт, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц нь ой модны хомсдол, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, газар ашиглалт, биологийн олон янз байдлын алдагдал, хоол хүнсний аюулгүй байдлын талаар санаа тавьж байдаг байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц ба НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц нь тухайн улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хамруулах явдлыг нэг мөр болгох явдлыг багтаасан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах үндэсний хэмжээний үйл ажиллагаа ба чадавхи; нэгдсэн стратеги, бодлогын баримт бичгийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх; улс ба орон нутгийн түвшинд зохицуулах, хэрэгжүүлэх механизмийн чадавхи; мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ ба менежмент; засаглалыг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжих ойролцоо сонирхолтай.

Хоёрдугаарт, харилцан уялдаа холбоо (синержи)-г хөхүүлэн дэмжих улс төрийн хүсэл сонирхол байгааг дэлхийн түвшинд харуулах явдал нь эдгээр конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ихэвчлэн нэг яам төвлөрүүлэн зангидаж байгаатай холбоотойгоор конвенцийн зохицуулагч нарын хамтын ажиллагааг мөн дэмжиж байгаа юм. Урьдчилсан судалгаагаар НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Биологийн төрөл зүйлийн тухай Конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц, Даян дэлхийн Байгаль орчны сан (GEF)-ийн Зохицуулагч нарын ядаж 3 нь Африкт 54 орноос 37-д, Азид 56 орноос 39-д, Латин Америк ба Карибын тэнгист 33 орноос 23-д, Хойд Газар дундын тэнгис, төв ба зүүн Европт 17 орноос 15-д нь нэг газар буюу нэг байгууллага дээр төвлөрч байгааг харуулсан дүр зураг гарчээ.

Эцэст нь өгүүлэхэд, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенцийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөрийн загварыг харахад харилцан биенээ нөхдөг байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь дороосоо дээшээ чиглэдэг ба орон нутгийн түвшинд үйл ажиллагааг авч явуулахыг ихээхэн шаарддаг. Харин Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь дээрээсээ доош чиглэсэн загвартай байдаг ба улс үндэсний хэмжээний хэрэгжилтийг ихээхэн шаарддаг байна. Хоёр конвенцийн хоорондын уялдаа холбоо (синержи) нь бодлогын түвшний интеграц, конвенцүүдийн хэрэгжилтийг илүү сайн хангах боломжийг олгоно.

Дээрх конвенцүүдийн тухайд улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэгч байгууллага хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдлыг дэмжих зорилготой. Эдгээр асуудлаар орон нутгийн түвшинд хамтран ажилласан туршлага нь улс үндэсний түвшин дахь илүү ойр хамтын ажиллагааны суурь болж болох юм. Конвенцийг хэрэгжүүлэх явцад харилцан уялдаа холбоог дэмжсэнээр нөөц бололцоогоо илүү үр дүнтэй ашиглах бөгөөд бие биенээ давтсан үйл ажиллагааг аль болохоор багасгаж, ингэснээрээ хамтран хуваалцаж болох үр дүнтэй ажил болох юм.

Ижил төстэй бодлого, стратегийг хамтарч боловсруулах, хамтран хэрэгжүүлж болох үйл ажиллагааг тодорхойлох; газрын тогтвортой менежментэд дэмжлэг үзүүлэх; мөн



байгууллага хоорондын хэлхээ холбоог бэхжүүлэх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, хамтарсан тайлан тавих, цөлжилт ба уур амьсгалын өөрчлөлттэй

тэмцэх шинжлэх ухаан технологийн шийдэл зэргийг хамтарч боловсруулах нь харилцан уялдаа холбоо (синержи)-г амьдралд хэрэглэж байгаа явдал болох юм.

Бодлогын зөвлөмж

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хөрсийг илүү үр дүнтэй ашиглах зорилгоор газар ашиглагчид газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, мөн хөгжлийн төлөө хамтрагчид буюу хандивлагчид, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенцийн гишүүн орнуудын улс хоорондын түвшин дахь харилцан уялдаа холбоог дэмжихүйц бодлого хэрэгтэй байна.

Газрын тогтвортой менежмент

- НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенцид газрын тогтвортой менежментийг бодлогын хүрээнд дэмжин, хөрс нүүрстөрөгчийг шингээх асуудлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн багасгах явдлыг дэмжих, нүүрстөрөгчийн ялгаралт, хөрсөн дахь нүүрстөрөгчийг алдагдалд хүргэдэг хөдөө аж ахуйн зарим арга туршлагыг бууруулах/багасгах
- Хөрсөн дахь нүүрстөрөгчийг уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нэг хэмжүүр болгож ашиглах
- Зохистой арга хэрэгслийг боловсруулж хэрэгжүүлэх, үүнд: амьдралын үйл явцын дүн шинжилгээ, ямар асуудлыг хэмжих хил хязгаар, алдагдал зэргийг нийтэд нь хамааруулан нэгтгэсэн нүүрстөрөгчийг хэмжих жиших түвшин, журам
- Цэвэр хөгжлийн механизм, Хамтын хэрэгжүүлэлт, Газар ашиглалт ба газар ашиглалтын өөрчлөлт, Ойн аж ахуй ба Хорт хийн худалдаа зэргээр дамжуулан хэрэгжүүлэх уур амьсгалын санхүүжилтийн хүрээн дахь бүтээгдэхүүнд хөрсөн дахь нүүрстөрөгчийн агууламжийг бууруулах буюу хөрсний нүүрстөрөгчийг шингээх үйл ажиллагааг хамруулах
- Дараах нөхцөлөөр нөхөн олговор олгох, үүнд
 - › Нүүрстөрөгчийн ялгаралтыг багасгасан байдлаар үйл ажиллагаагаа эрхэлж байгаа, биотүлшийн эрчим хүчний бүтээмжийг дээшлүүлж байгаа, хөрсний элэгдлийг хяналтандаа байлгаж байгаа зэрэг аргаар хөрсний элэгдлээс зайлсхийсэн,
 - › хөрс нүүрстөрөгчийг шингээх ажиллагаа, үүнд ялангуяа: хөрсийг хамгаалах дэвсгэр хаалт, тариалангийн бүтээлэг, хөрсний засвар (бионүүрс, өтөг, цеолит гэх мэтийг нэмэх) зэргээр дамжуулж нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулж байгаа; мөн биобордоо, химийн бордоо зэргийг ашиглан хөрсний үржил шимт чанарыг нэмэгдүүлж байгаа;

- › хөрсний элэгдэлд орж доройтсон газар, саванныг нөхөн сэргээх, хөрсний элэгдэл хорогдолд хяналт тавих зэргээр хөрсөн дахь нүүрстөрөгчийн агууламжийг нэмэгдүүлэх стратегийг хэрэглэж байгаа

Хөдөө аж ахуй

- Хөдөө аж ахуй эрхлэгчдийг уур амьсгалын өөрчлөлтийг багасгах түлхүүр бүлэг болохыг хүлээн зөвшөөрч хөдөө аж ахуйн талаарх өргөн хүрээтэй хэлэлцүүлгийг зохион байгуулж нэг мөр ойлголттой болох
- Нүүрстөрөгчийн кредит хөтөлбөр, хөдөө аж ахуй эрхлэгч нар хамтын үйл ажиллагаагаараа экосистемийн үйлчилгээ үзүүлж байгаа мөн засгийн газрын хөтөлбөртэй хамтран ажиллаж байгаагийн төлөө төлбөр төлөөс олгох
- Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх буюу дасан зохицох чанарыг агуулсан хөдөө аж ахуйн тогтвортой үйл ажиллагааг дэмжсэн урамшууллыг нэмэгдүүлэх
- Амьдралын үйл явцын дүн шинжилгээг хамруулсан хэмжигдэхүүнийг бий болгох
- Хөдөө аж ахуй эрхлэгчдийн санхүүгийн циклтэй нягт хамааралтай зах зээлийн урамшууллыг бий болгох.
- Жижиг хэмжээний фермтэй хөдөө аж ахуй эрхлэгчдэд зориулж нэг нь нөгөөгөө дэмжих, эцэстээ нийлж байж бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга үйл ажиллагааг боловсруулах

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын суурь Конвенц ба НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн Үндэсний зохицуулагч нарын ажлын харилцан уялдаа холбоо (синержи)

- Газрын тогтвортой менежмент зэрэг түлхүүр санал санаачлагыг тойруулж нэгдсэн ойлголт бий болгох
- Хамтын ажиллагааны ерөнхий удирдамж, хүрэх зорилтоо нарийвчлан тодорхойлсон Үндэсний зохицуулагч нарын тодорхой үүрэг хариуцлагыг бий болгох
- Хамтын ажиллагаа зайлшгүй шаардагдах үйл ажиллагааг дэмжих, урамшуулах
- Бүх түвшинд засаглалын асуудлыг тусгаж байх
- Байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулах
- Чадавхи бий болгох
- Хүний нөөцийн хөгжил, байгууллага хоорондын зохион байгуулалт уялдаа холбоо, эзэмшсэн мэдлэг, эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох механизм зэрэг ирээдүйн бүтэц хамтын ажиллагааг бий болгох.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн тухай

Риогийн дээд хэмжээний уулзалтын үр дүнд бий болсон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц (United Nations Convention to Combat Desertification, UNCCD) нь дэлхийн хамгийн эмзэг экосистем, хүн амд газрын доройтол хэрхэн нөлөөлж байгаа асуудалд анхаарал хандуулах өвөрмөц арга хэрэгсэл юм. Хүчин төгөлдөр болсноосоо хойш 13 жилийн дараа тус конвенц нь Риогийн гурван конвенцийн хамгийн том гишүүнчлэлээс ашгаа авч, тогтвортой хөгжилд хүрэх ба ядуурлыг бууруулахад чухал үр нөлөө үзүүлэх хэрэгсэл болох нь хүлээн зөвшөөрөгджээ. Хуурай гандуу газар нутаг дахь ган гачгийн асуудалд гол анхаарлаа хандуулсан НҮБ-ийн мандаттай цорын ганц байгууллага гэх утгаараа НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц нь ган гачиг ихээр тохиолддог болон уур амьсгалын нөлөөнд анхлан өртөж байгаа улс орнууд хялбарханаар дасан зохицоход хэрэг болох арга хэрэгслийн талаар НҮБ-ын системд бодлогын заавар зөвлөлгөө санал санаачлагыг гаргаж өгдөг. Мөн Уур амьсгалын асуудлаархи НҮБ-ын суурь Конвенцийн гишүүн орнуудад өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа ба шинээр байгуулах гэрээ хэлэлцээр дахь холбогдол бүхий дутагдлын талаар зөвлөгөө өгөх үүрэгтэй.